

**ТАЙЛАХ УХААН ШИНГЭСЭН
ХОЁР БҮТЭЭЛИЙН ТУХАЙД**

Д. Цэнджав *

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн цагийн цагт хэлбичиг, утга зохиолын үндсэн гол судалгааг дагнан гүйцэтгэж доривтой томоохон бүтээлүүдийг гаргасаар ирсэн түүхтэй. Сүүлийн жилүүдэд эрдэмтдийнхээ оюуны бүтээмжээ улам нэмж, монгол үндэснийхээ соёлын өвийг бүрдүүлж бүтээхэд анхаарч, даацтай тулхтай ном бүтээл гаргаж байгаа нь урамтай санагддаг. Харанхуйд бүдэгт дөнгөж гэгээ тусаж байсан хорь гучаад онд Судар бичгийн хүрээлэн гэгч нь чухамхуу гэрэлт цамхаг болж, бичиг эрдмийн өвгөд налайтал сууж, өвгөд дээдсийн үлдээсэн асар их шастир бичгийн шарласан хуудас эргүүлж, соён гэгээрлийн үүдийг анх сөхжээ. Хур эрдэмтэй, хуучны тулхтай, бийр янтай, билэг номын эрдэмтүүд адис аваад ордог газар байжээ. Ном номын дотроос толь бичиг болбаас харанхуй цээж рүү тусгах гэрэл гэгээ мөн. Бичгийн буурал мэргэд энэхүү толь бичиг буюу их зөв зүйтэй зүйлээс эрдэм ажлын гараагаа эхлүүлсэн байдаг. Хориод онд Ч.Бат-Очир, Сутай уулын Л.Мишиг манжич нар “Монгол үгийн тайлбар толь”(1921- 1927) С.Шагж “Эрдэнэ мэт үсгийг хялбар эвлүүлж чимэг болгон хэрэглүүлэх амар хөтөлбөр оршвай” (1927) “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгийн тайлбар чандманийн эрхи”(1929) 27000 толгой үгтэй орчин үеийн хэл шинжлэлийн аргыг үндэс болгон “Үсгийн дүрмийн толь бичиг”(1933) хэмээх толиудыг зохиожээ. Я.Цэвэл гуайн “ногоон толь” гандан буурахгүй, олон арван жил нүд чих болж явлаа. Улстөрчид, хуульчид, эдийн засагчид хүртэл үгийн тайлбарт гацаад ирэнгүүт “Монгол хэлний тайлбар тольд” үүнийг ингэж тайлбарлажээ” гэж ярьж сурсан нь үнэт ч зүйлсийг өргөж байгаа ахиц дэвшил юм. Уг нь “Ном унших” гэдэг шиг “Толь унших” гэсэн хөдөлгөөнийг оюутан, сурагчдын дунд өрнүүлмээр байгаа юм. Хэрэгцээ гарвал хааяа нэг сөхөж үзэх биш, нэг толийг дуустал хэд эргэлдүүлэхэд ертөнцийг тархи биедээ шингээгээд авчихаж байгаа хэрэг. Даацтай том туурвил бол 80 мянган толгой үг, 120.000 орчим үг хэллэгийг багтаасан таван боть “Монгол хэлний их тайлбар толь” гаргасан нь эрдэмтдийн нөр их ажил байсан нь тодорхой. Гэсэн хэдий ч наад захын үг хэллэг орхигдсон байна лээ. Нурууг нь босгосон хоойно майхан босч л таарна.

Ажвал, эртний болоод эдүгээгийн утга зохиол судлалд залуус хүч түрж орж ирсэн бололтой. Шуурмаг хурдан болоод чансаатай зүйлийг бүтээнэ гэдэг өнөөдрийн хэний ч эрхэмлэх зүйл яах аргагүй мөн л дөө. Хуучин цагт нэг толины сураг гараад 10 жил

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Утга зохиолын тэнхим

болдог, арван жил болоод бүрмөсөн алга болдог гэм биш зан байсан. Хэвлэгдсэн зүйл болгоныг авах, үзэх, судлах бололцоогүй юм. Академич Д.Цэрэнсодномын “Монгол ардын аман зохиол”, С.Байгалсайхан, Д.Сумьяа, Д.Болормаа нарын “Монголын уран зохиолын дээж бичиг” нарын суурь бүтээл гарчээ. Залуу эрдэмтэн Д.Болормаа “Монголын утга зохиолын судлал шүүмжлэлийн номзүйг”(1970- 2000) гаргаснаараа 30-аад жилийн тасалдлыг нөхөж чаджээ. Ерөнхий утга зохиолын бүтээлийн ном зүйг эрдэмтэн М.Баянзул, Х.Сампилдэндэв, Д.Өлзийбаяр, Б. Сумьяабаатар нар гаргаж байсан бол Д. Болормаа зөвхөн судлал, шүүмжлэлийн номзүйг гаргаснаараа судалгааны ажилд ихээхэн тус болох нь дамжиггүй. Номзүй гэдэг бол эрдэмтэд, магистр, докторант, судлаачид, сонирхогчдод тусалж, монголч эрдэмтдэд бүтээлийн мэдээллийг хамгийн шуурхай, хамгийн баталгаа нотолгоотойгоор өгч байгаа “номын түргэн тусламж” гэхэд болно. Бас өөрөөр өнгөрсөн одоо, уламжлал шинэчлэл, хуучин шинийг холбож өгч байгаа алтан аргамж юм. Энэхүү аргамжаас атгаж авбал хэн, хэзээ, хаана, юу бүтээв гэдэг мэдээллийг шууд аваад түүнийгээ номын сан, номын сүлжээ, хувийн номын сан, хүмүүсийн гар дээр байгаа номууд, гадаад дотоодод эрвэл юу эрж хайснаа олох бололцоотой. Номзүй, толь хоёр амар ажилбар биш. Олон сонин хэвлэлийг шүүрдэн үзэх шаардлагатай чимхлүүр бэрхшээлтэй, цаг хугацаа ихээхэн шаарддаг хөдөлмөр юм. Залуу эрдэмтэн Доржсүрэнгийн Болормаа эхнээсээ зөв зүйтэй зүйлийг барьж, энэхүү номын хязгаарыг 1970-аас 2000 он хүргээд орхисон тул түүнээс хойш гарсан шүүмж, судлалын өгүүллээр дараачийн ном төрөх бололцоотой.

Одоо өвөрт орж ирж, гарт баригдснаар Д.Сумьяагийн “Монгол ногоон дара эхийн тууж”, Б.Мөнхбаярын “Монголын уран зохиолын тайлбар толь” номууд анхаарлыг зүй ёсоор татсан тул үүнд тогтож өгүүлье. Танин мэдүүлэх, хүмүүст санаа өгөх бишгүй арвин зүйлтэй энэхүү хоёр номын зохиогчдод утга зохиол сонирхогч хэн боловч талархана байхаа.

“Чойжид дагинын тууж” “Молом тойны намтар” “Дара эхийн туужийг” сайн ухаж ойлгохгүй ч бага балчираасаа сонсож өсчээ. Үгийг чихний хонхорцогтоо ухаан болгож торгоохгүй ч гэсэн халт сонссон байх нь басчиг судрыг нь мэдэхгүй ч баринтагны бүснээс барьж өссөнийх юмаа. Мэндбаяр хошуу туслагч, “ерөнхий” хэмээх Цэдэв тайжийн үлдээсэн судар, ном хойт арслантай эрээн авдаранд байх. Ээж минь номонд тун хорхойтойсон. Андуу Ринчен гэгч төвд, монголтой бадарчин гэмээр хамаатан хааяа манайхаар явган яваад ирнэ. “Номын хүдэг” туссан гэлцдэг тэрбээр сүүлд Өлзийт сум руу гараад чимээ тасарсан. Дээл хувцас ч хамаа намбагүй, үргэлж инээгээд л шашин бурхан, там диваажин, хойт нас, нүгэл буян гээд дэвэн дэлхийн янз бүрийн хачирхалтай зүйлийг хөөрдөг, өөрийгөө мартсан мэт хачин хүнийг гэртээ байлгаад, хоёр гурван хоног бүх номыг уншуулаад ээж минь жигтэйхэн зүс царай ороод “Сайхан боллоо. Ааваасаа хойш гар хүрээгүй юм. Эцэг минь ёстой л өөх тос халгиж байгаа шиг шударга сайхан уншдагсан. Дуу хоолойг нь яана. Энэ Андуу аавыг минь арай л гүйцэхгүй байна. Цээж онгойлоо. Бид чинь энэ насан төрлийг орхиод энэ “Дара эхэд” гарч байгаа шиг тийм оронд төрөх ёстой юм гэнэ лээ. Эрлэг номун хаанд очиход хамгийн өршөөлгүй нүгэл бол эм хүний садар самуун явдал гэдэг юм гэнэ лээ. Эх хүн гэдэг мөн хачин шүү...” гээд нулимс унагааж байсан нь эрдэмтэн Д.Сумьяагийн олон эхийг олж, эмхэлж, судалж, харьцуулж гаргасан “Монгол ногоон дара эхийн туужийг” уншаад тээр жилийг санагалзав. “Молом тойны намтар” л гээд ээжээсээ сонссон болохоос угтаа бол “Молон тойны эхдээ ач хариулсан судар” гэдгийг дээд сургуульд ороод мэдэж авсан. Завхай тачаангуй, чивэл нүгэлт, буян хийдэггүй эхдээ Молон тойн

наад зах нь маани унш гэж шахдаг шаарддаг боловч үгэнд нь орохгүй зөрж нүгэл нь зузаарсаар нас халиад арван найман тамын тогоонд унажээ. Молон тойн тамын орноор явж эхийгээ барьж явсан эрхийрээ татаж гаргаж ирдэг энэхүү бурхан шашны болон гайхалтай уран сэтгэмжийн зохиолыг Ц.Дамдинсүрэн гуай олон хувилбараар нь судалсан юм. Харин бүр сүүлд 2009 онд доктор С.Хишигсүх шавь С.Энхбадрахтай хамтаар Завхан аймгийн Идэр сумын иргэн Л.Нарангэрэлээс “Хутагт Молон тойн эхлээн ач хариулсаны судар оршбай” олж өнөөгийн монгол бичгийн хэлнээ буулгажээ. Миний их гэрийн голомтод ээжийн минь дээдэлдэг “Молон тойны намтар” чухам ямар хувилбар нь байсныг мэдэх сөхөө байсангүй. Номонд нэргүй хөндий цээжит хойдын залуус эс тоон яаж үгүй хийснийг бас мэдэхгүй. Ээж маань “Садар эмийн нүгэл цайрдаггүй юм гэнэ лээ” гэж ярьдагийн учир энэхүү Молон тойны намтартай холбоотой болохоор нуршихийв.

Ер нь бурхан шашны сэдэвт зохиолууд нүгэл, буян, там диваажинтай холбоотой, аль болох нүгэлгүй буян хийж амьдрахыг сургасан нь олонтаа. Түүний нэг нь “Монгол ногоон Дара эхийн тууж” юм. Эртний ном зохиолыг судална гэдэг амаргүй. Ганцхан нугалаасны балархай арван үгийг яагаад ч сэргээхийн аргагүй тасалж чадна. Тайлахад бэрх үг олон гарах нь мэдээж. Энэ бүхний цаана Д.Сумьяа гарч, “Ногоон Дара эхийн” судлалыг урагшлуулахад хувь нэмэр оруулжээ.

...Үхмээр байна

Өнөөдрөөс хэтэрмээргүй байна

Хүмүүсийн дунд холхих мөртлөө

Хүмүүст би мартагдчихжээ

Байшин барилга бүгдийг нурааж

Бас дахиад шинээр баримаар бодогдоно

Багадаа бичсэн хэдэн шүлгийг минь ч

Бас л таг мартчихаж шүү

Мартахаас илүү намайг яаж шийтгэх юм

Маргаашийн шүлэггүйгээр би яаж үхэх юм... гэж наяд онуудад нэвт гэрэлтэй, нэвт уйтай, нэвт дүрслэлтэй, ур хийц хоёр тэнцүүхэн ухаарлын болоод дүрслэлийн донжтой шүлэг бичдэг байсан тэрбээр шүлэг яруу найргаа орхиод үсэг балархай, утга тод бус, эрэлт хайлттай эртний уран зохиол, судар номын судлалд шимтсэн өөрийнх нь нэгэнтээ шүлэглэсэн,

Бидэнд гучдугаар зуун ирээгүй домог

Бид гучдугаар зуунд өнгөрсөн домог гэж ёстой домог болсон юмны учрыг олохоор чөмөг дундлан сууж, үгийн утгыг малтсан бичиг номын хүмүүн болжээ. “Монголын орчин үеийн яруу найраг” гэсэн хоёр дэвтэр судалгааны ном гаргаад амжчихаж. Их төвдөч, өөрийн түшээ багштан Л.Хүрэлбаатарт сайтар нухлуулсны ач биз, бас дараа нь энэ цаг үеийн гарын таван хуруунд багтах голч нуруутай, зөв баримжаалалтай судлаач, онолч, шүүмдэлгч С.Байгалсайханы залуур, эрдэм номын цацлага хаялга байхаа.

“Ногоон Дара эхийн туужийг” гараар нэг бичээчээс нөгөө бичээчид, нэг айлаас нөгөө айлд дамжуулан хуулан бичиж хадгалагдаж ирсэн олон хувилбартай. Бичээч нарын нэгэн талын чухал үүрэг бол ерөөс хуулж тараах, нэн ялангуяа бурхан шашны сэдэвт зохиолыг хуулж тараах нь их буяны үйлс байсантай холбоотой. Д.Сумьяа нэгэн сэдвээр дагнан, эрэл хайгуул сайн хийжээ. “Ногоон Дара эхийг” үндэсний номын сан, Хэл зохиолын хүрээлэн, Ц.Дамдинсүрэнгийн гэр музей, ӨМӨЗО”ны номын сан,

Шинжаан Уйгарын номын сан, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын монгол, төвд, бүддийн судлалын хүрээлэнгийн гар бичмэл, Унгарын Будапештэд хадгалагдаж байгаа гар бичмэг зэрэг 30 гаруй эхийг үзсэн нь эрдэмтэн хүний сэтгэлээ зориулсан эрэл хайгуул, түрүү үеийн номын мэргэд багш нарын дэг, хөдөлмөр, сургамж сургаалийг чухагаар үргэлжүүлж байгаа хэрэг мөн.

Ногоон Дара эхийн сүм хийд ч бий. Хүн бүр л шүтдэг. Харин эрдэмтэн Сумьяагийн энэхүү номын буянаар олон газар тархсан ногоон Дара эхийн маш олон хувилбарыг харьцуулан үзэж болохоор нэгэн бодлын “Дара эхийн” нэгдсэн цуглуулга юм. “Ногоон Дара эхийн агуулгаар нь А,Б, В, Г гэж дөрөв ангилж, зөрөө болон адил төстэй тал зэргийг нарийвчлан судалжээ. Энэ тууж нь шашны болоод урансайхны, аман болоод бичгийн, монгол болоод бүддийн гэх олон үзэл ойлголтын нийлэг уулзварын үзэл ойлголтыг илт онох атлаа хийсэвэрлэл бясалгалын олон дүр дүрслэлийн арга барилаар зохиосон тууж гэсэн дүгнэлтэд хүрчээ. Хуулан түгээхдээ өөрийн санаагаа оруулсан энэ олон хувилбар дотроос хамгийн анхны эх аль нь вэ? гэдгийг зэрэгцүүлэн судлаад “Тоолш үгүй нэгэн галавт” хэмээх хувилбар монгол “Ногоон Дара эхийн тууж” нь анхдагч гэж үзснээрээ сонирхол татна. Төвдөөс орчуулсан зохиол биш, монгол хүний ой ухаанаар үүдэн зохиогдож, бичгийн мэргэд бийрээ хүргэх бүр улам баяжигдан дэлгэрч ардын баатарлаг туульсийн дүр дүрслэлтэй ольж хутгасан ардын шажны туулилаг тууж юм гэсэн нь Ц.Дамдинсүрэн гуайн дэвшүүлсэн санааг дэмжсэн байна.

Ногоон Дара эхийн агуулга ер нь хоорондоо төсөөтэй. Ногоон Дара эх насны эцэст сайн цагийн мянган бурхдаас үрийн хутаг гуйна. Түүний үрээр сайхан хүүтэй болно. Энэ хүүг хувилбар бүрт маш уран тод үгээр дүрсэлжээ. Энэ бол ерийн нэг шажны зохиол биш, уран сэтгэмжит, хийсвэрлэл төгс, хэл найруулга үнэхээр гайхалтай учраас их өргөн таржээ. Хүүг *“очирваань бурханаас үндэслэж, ургасан наран мэт өнгөтэй, улаан бямбын өнгөтэй, өндөр Бяруузана мэт тэгш сайхан биетэй, хас эрдэнэ шүдтэй, галбарагсан мод мэт нуруутай, бодитой бурхны дүртэй, Аюун нэртэй бодисал хөвүүн гарвай”* гэсэн нь дүрийг гаднаас зурж дүрслэх, түүнд бүхий л үгийн баялан санг ашигладаг уламжлал эрт үеэс байсныг гэрчилнэ. “Хөх судар” романд ийм дүрслэлээр нэн баялаг нь тааралддаг.

Арай гэж олдсон хүү гурав хоноод үгүй болж байгаа нь жинхэнэ уран сайхны шийдвэрлэл бөгөөд зохиолын үүдэл санаа юм. Энэхүү үүдэл санааг цааш нь юу болгож хөгжүүлэх вэ? гэдэг асуулт аяндаа гарна. Энэлэнд автсан Дара эх дээд дэнгэр, дунд Замбуутив, гадаад далай, лусын орон, тамын орноор хүүгээ хайна. Гайхалтай сайхан уран зохиол гэдэг нь эхийн шаналалыг хурц тодоор зурж өгсөн байна. *Ногоон Дара эх хүүгээ алдаад бөөрөн зүрх нь булиглаж, богино хавирга нь мэхэлзэж, дөрвөлжин улаан сайхан цээж нь балай харанхуй бол, бат сайхан сэтгэлийг донслон донгодож дээд газрыг дэнсэлтэл, доод газрыг донсолтол хувхай модноос навч цэцэг ургатал, хонхор газар нуур далай тогттол ангинан уйлж, хоёр юндэн хөх нь ширгэн одвой* гэжээ. Иймэрхүү нандин үгийг золхилдуулан залах гэж бичгийн сайдууд мөн олон муутуу цаасыг урж, мөн олон бийр янтайг үрээ бизээ гэж эрхтгүй бодогдоно. Монгол ухаан, монгол соёл, монгол мэдлэг гэж тусдаа юм байргүй гээчдэд бэлтэйхэн барих хариу бол энээ. Уран сайхны сэтгэмжээр Алигери Дантейн “Там”, “Ариутгалын орон”, “Диваажингаас” дутахааргүй.

За тэгээд гол үйл явдал хөвөрсөөр мэргэн цагаан багшид хүрч очоод зурхай зуруулж, дэдэ тэнгэрийн мянган бруханы орноос хүүгээ олж, хоёул Замбутивд буун ирж суварга босгон даяан бясалгал хийж, тамын амьтны зовлонг гэтэлгэн, амьтны

тусыг бүтээж байна. Эртний уран зохиол бүрийг шажных гэж үзүүлэж, хэлэх ёстой үгийнхээ хэлтэрхийн чинээг агуу их ухааны ай савд багтаан хэлж ирсэн Дамдинсүрэн номчийн мэргэнээр тавьсан замаар Д.Сумьяа зөв явнаа гэж бодохоор байлаа.

Өөр нэг баярласан ном бол залуу эрдэмтэн Б.Мөнхбаярын “Монголын уран зохиолын тайлбар толь” хэмээх томхон бүтээл юм. Энэ ном нэн ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн хэл-уран зохиолын багш бүрийн ширээний ном болохоор өгөөжтэй, хураангуйлсан тодорхойлолт, цэгцтэй үнэлгээ, шимж шүүсэн бүтээл эшлэл арвин, хэл найруулга нэн ойлгомжтой хүсэн хүлээсэн бүтээл туурвилын нэг болсон байх юм. Монголын эрт эдүгээгийн эрдэнэс болсон утга зохиолын талаархи мэдлэг мэдээлэл, хялбарчилсан шинжлэх ухаан, танин мэдэхүйг нэгэн дор хураан үзүүлж чаджээ. Өнгөрсөн эдүгээгийн ховор олон материалыг ашиглаж, өөрийн дүгнэлт гаргалгаа хийж, шинэ санаа, сэргэг үзлээр нэн цэгцтэй ойлголт өгч чадсан өө сэвийг сайтар дарсан хичээнгүй ном болсон байдал нь манай утга зохиол шинжлэлд байраа зохих эзлэх нь тодорхой. Профессор Д. Галбаатар “Уран зохиолын нэвтэрхий толь” гарсан. Монголын оюун санааны хөгжил утга зохиолоос л эхэлнэ. Манай үндэсний сэхээтнүүд одооноос л юмандаа эзэн болж чадаж байна. Тайлбарлах ухаан, сүүлийн үеэс хүчээ авч байгаа утга зохиолын шинжлэлийн герменетикийн аргыг Б.Мөнхбаяр эзэмшсэн нь харагдана. Онолын маргаантай бэрх нэр томъёог ч монголоор зөв буулгаж, эвсэг найруулгаар имчдэж, ухагдахууныг өргөн цараатай гаргаж чадсан нь нэн олзуурхууштай. Мэдлэгийг эмхэлж хураангуйлна, жагсаан эрэмбэлнэ, голын олж тайлбарлана, утга зохиолын нарийн үзэгдлийг таньж мэднэ, олон талаас нь харж шинжилнэ судална гэдэг дурын аавын хүүгийн ажил биш. Монголынхоо уран зохиолын хөгжлийн түүхийг “Нэн эртний, эртний, ХХ зууны уран зохиол” гэсэн хүрээнд, монголын уран зохиолын цаг цагийн гол гол төлөөлөгчдийн уран бүтээлийн хамт авч үзсэн нь номын агуулга бүтцийг баялаг болгож байна. Олдоц муутай бүтээлийг бүрэн эхээр нь оруулсан тохиол ч үзэгдэнэ. Олон ном зохиол, цөөнгүй судлаач шинжээчийн үнэлгээг өөрийн бодлоор эргэцүүлэн хүлээн зөвшөөрөхүйц хэмжээний томъёолол, гаргалгаа үнэлэлт өгснөөр номоо уран зохиол сонирхогчдын номын санд оруулахуйц чанартай бүтээл гэж үзмээр байна. Энэ мэт оюуныг хөгжөөсөн, бага балчрыг эрдмийн бэлчирт хүргэсэн, үг үсэг бүрээс нь гэрэл гийх ном арвин гаргахыг эл хоёр эрхмээс хүсэх зүй.